

736X

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 93

Тэрийн ордон, Улаанбаатар хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар
2016 онд баримтлах үндсэн чиглэл
батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дунд хугацаанд төсвийн нэгдмэл байдлыг хангасан бодлого хэрэгжүүлэн улсын төсвийг алдагдалгүй байлгаж, гадаад валютын орох ўргсгалыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийн тогтвортой байдлыг ханган, улсын өрийн зохицтой удирдлагыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

3.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн өзөв /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/-нд тус тус даалгасугай:


1/санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийг хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах;

2/улсын төсөв, санхүү, мөнгөний бодлогыг эдийн засгийн бодит секторыг дэмжих, хувийн хэвшлийн идэвхжилийг сайжруулахад чиглүүлэх;

3/Монгол Улсын зээлжих зэрэглэл, эдийн засгийн орчныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах;

4/зээлийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн зуучлалын үр ашгийг нэмэгдүүлэх замаар зээлийн жилийн хүүг дунджаар 1-3 хувиар бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Батсуурь/-нд үүрэг болгосугай.



3.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2015 оны
93 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
2016 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Мөнгөний бодлогын үндсэн зорилт нь эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь болох макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж ~~банк~~ санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэнэ.

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1.Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2016 оны эцэст 7 хувьд, 2017-2018 онд 5-7 хувьд тогтвортжуулсны үндсэн дээр эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг ханган эдийн засаг тогтвортой өсөх нөхцөл бүрдүүлнэ.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримтална.

2. Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

2.1.Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

2.3.Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлээр дотоод, гадаадын эрх бүхий байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1.Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөрийн системийн шинэчлэлийг эрчимжүүлж, эрх зүйн орчныг сайжруулна.

3.2.Санхүүгийн салбарын активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.3.Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамtran үе шаттай хэрэгжүүлнэ.